



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 108

Баянтал сум

Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын
зардал батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4, 9.4.2 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэр дээрх хог хаягдлыг цуглуулах, төв хогийн цэгийг түрж булшлах, нохой муур устгал хийх ажлыг Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын зардлаас зарцуулахыг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д даалгасугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

2026 оны 09 сарын 02 өдрийн
тушаалын хавсралт



Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын төсвийн задаргаа

№	Хийгдэх ажлууд	Төсөв
1	Цалин	20,400,000
2	НДШ ажил олгогчоос	2,550,000
3	хогны машины сэлбэг	2,504,000
4	хөдөлмөр хамгааллын хувцас	960,000
5	Хогны машины шатахуун	2,880,000
6	Төв хогийн цэгийг түрэх шатахуун	4,680,000
7	Нохой муур устгалын шатахуун, ажлын хөлс	4,026,000
8	Нийт дүн	38,000,000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/05

Баянтал сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2026 оны төсөвт батлах” тухай 03 дугаар хуралдааны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит 01 дүгээр хуралдаанаар хэлэлцэж баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн “Гамшгаас хамгаалах зардал” арга хэмжээний **55,000,000** /тавин таван сая төгрөг/ төгрөгийн задаргааг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2.Дээрх хөрөнгийг 2026 оны сумын төсөвт тусгагдсаны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Б.Солонгомаа)-д даалгасугай

3.Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Эрхэмбаатар) д үүрэг болсугай



Э.БАТТУЛГА

Гамшгаас хамгаалах арга хэмжээний задаргаа

№	Арга хэмжээ	Төсөв
1	Сумын ЭМТ-ийн ариутгал халдваргүйжүүлэлтийн хувцас	2,500,000
2	Сумын Онцгой Комиссын шатахууны зардал	5,540,800
3	Засмал замын хальтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж замын давс худалдан авах зардал	1,500,000
4	Дизель генераторыг сэлгэн засвар зардал	1,175,000
5	3 бэлчирийн шугамын засварын ажил	38,374,200
6	Сумын онцгой байдлыг хангах багаж тоног төхөөрөмжийн зардал	5,910,000
Нийт		55,000,000



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/04

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.1, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2026 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “ЕБС-ийн подвалын цэвэр, бохир усны шугам шинэчлэх, засварлах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар (Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Цэрэнням (ЕБС-ийн захирал)
М.Ууганбаатар (ЕБС-ийн аж ахуйн нярав)


Нарийн бичгийн дарга:

Н.Баярмаа (ИТХ-ын төлөөлөгч)
Ц.Булган (ЗДТГ-ын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийн зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Э. БАТТУЛГА





ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/03

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2026 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Эрүүл мэндийн төвийн ноорогт хөргүүр, тоног төхөөрөмжтэй болох” барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Э.Эрхэмбаатар (Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

М.Ууганбаатар (ЕБС-ийн аж ахуйн нярав)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

Ц.Булган (ЗДТГ-ын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э. БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/02

Баянтал сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Баянтал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2026 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгөөр хийгдэх “Нийтийн халуун усны барилга барих” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Э.Эрхэмбаатар (Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

М.Амаржаргал (Талын Илч ОНӨААТҮГазрын ХАЭБ-ийн ажилтан)

Н.Сарантуяа (ЗДТГ-ын аж ахуйн нярав)

Д.Сувд-Эрдэнэ (ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

Ц.Булган (ЗДТГ-ын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Эрхэмбаатар)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э. БАТТУЛГА



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Баянтал сум

2027 оны Газар зохион байгуулалтын
төлөвлөгөө боловсруулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, 25 дугаар зүйлийн 25.4, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.24.2 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2027 оны тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ш.Шинэбаяр (Засаг даргыг Тамгын

газрын дарга)

Гишүүд:

Э.Түмэн-Эрдэнэ (Лүн багийн Засаг дарга)

Т.Ган-Эрдэнэ (Их уул багийн Засаг дарга)

(Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

(Бэлчээр, газар тариалан хариуцсан

мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

Б.Батчимэг (Газрын даамал)

2.Ажлын хэсгийн ажиллах ажил үүргийн хуваарийг нэгдүгээр, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын газар зохион байгуулалтын 2027 оны төлөвлөгөөний төслийг холбогдох журмын дагуу боловсруулж, 2026 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ш.Шинэбаяр)д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БАТТУЛГА

Сумын Засаг даргын 2026 оны
 07 дугаар сарын 26-ны өдрийн
 07 дугаар захирамжийн
 07 дугаар хавсралт


ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
 АЖЛЫН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ажлын хэсгийг хуралдуулах, төлөвлөгөө боловсруулах	2026.06.20	Засаг даргын тамгын газрын дарга
2	Бэлтгэл ажлыг аргачлалын дагуу газар зохион байгуулалтын ажилд шаардагдах төлөвлөлт тус бүрээр зураг, техник хэрэгслийг бэлтгэх	2026.06.20	Нарийн бичиг
3	Бэлтгэл ажлын аргачлалыг танилцуулах семинарыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зохион байгуулах	2026.06.20	Газрын даамал
4	Санал авах ажлыг зохион байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зөвлөмж өгөх	2026.06.25	Газрын даамал
5	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, бүлгүүдээс веб системээр болон уламжлалт аргаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг авах	2026.09.15	Багийн Засаг Газрын даамал
6	Багийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг тусгах ИНХ-аар хэлэлцүүлж санал авах	2026.09.15	Багийн Засаг дарга нар
7	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг сумын Газрын даамалд нэгтгэн хүргүүлэх	2026.09.20	Багийн Засаг дарга нар
8	Ирүүлсэн саналыг эрэмбэлэн шалгаруулж нэгтгэх	2026.09.25	Ажлын хэсэг
9	Шинээр гаргах, засварлах, эзэмшүүлэх, худаг уст цэгийн талаар малчид, малчдын нөхөрлөл, бүлгийн саналыг үндэслэн байршлыг тогтоож, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах	2026.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн

10	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр хийгдэх ажлын байгаль орчны үнэлгээ гаргах	2026.09.30	Хөгжлийн бодлогын тасгийн дарга
11	Бэлчээр ашиглалтын улирлын хуваарь, амрааж өнжөөх бэлчээрийн хуваарийг тогтоох	2026.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
12	Бэлчээрийн хортон, мэрэгчидтэй тэмцэх газрын төлөвлөгөөнд тусгах	2026.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
13	Бэлчээр хадланг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, ургац нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоо судалгааг гаргах	2026.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
14	Ашиглалтгүй бэлчээрийн судалгааг гаргаж, ашиглах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх	2026.09.30	Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
15	Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийн ашиглалт, хамгаалалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх	2026.09.30	Газрын даамал
16	Төлөвлөгөөнд тусгагдаагүй төлөвлөлтийн талаархи саналын хувилбаруудыг гаргаж, ажлын хэсгийн хуралдаанаар оруулж батлуулан Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулах	2026.10.05	Газрын даамал
17	Сумын 2027 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгдсэн цахим системд байршуулж, аймгийн ГХБХБГ азарт хүргүүлэх	2026.10.10	Газрын даамал
18	Сумын 2027 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийн хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх	2026.12.20	Газрын даамал

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Сумын Засаг даргын 2026 оны 01...
 дугаар зарын 03-ны өдрийн дугаар
 захирамжийн дүгээр хавсралт



**СУМЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН
 ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

Д/д	Албан тушаал	Ажил үүргийн хуваарь
1	Засаг даргын тамгын газрын дарга	Ажлын хэсгийг хуралдуулах, ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарийг ногдуулах, шуурхай удирдлагаар хангах, ажлын хэсгийн хамт Засаг даргын зөвлөл, ИТХ-д оруулах
2	Нарийн бичиг, Газрын даамал	Бэлтгэл аргачлалын дагуу хангах, аргачлалыг танилцуулах семинар зохион байгуулах, ажил үүргийн хуваарь гаргаж ажлын хэсгийн ахлагчид танилцуулах
		Иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, Хоршоо ААН-ийн гэрээ (лицен)-ээр эзэмшил, ашиглалтанд байгаа газрын хил заагийг газрын зурагт оруулах
		Санал авах ажлыг зохион байгуулах, ажлын хэсгийн гишүүдэд семинар өгөх
		Саналыг эрэмбэлэн шалгаруулж нэгтгэн төлөвлөгөөнд тусгах, эзэмших, ашиглах, нөхөн сэргээх, хөрөнгө оруулалт хийх газрын байршил, хэмжээг газар дээр нь очиж GPS багажаар хэмжих, зурагт буулгах, ажлын хэсгийн гишүүдийн гүйцэтгэсэн санал, төлөвлөгөөг нэгтгэн газар зохион байгуулалтын зураг төслийн хэлбэрт оруулан зохих програм хангамжаар боловсруулан ажлын хэсгээр батлуулах
3	Багийн Засаг дарга	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын нөхөрлөл, бүлгүүдээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах санал гаргуулах
		Багийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, малчдын бүлэг, нөхөрлөл, малчдын саналыг багийн түвшинд нэгтгэх, багийн зүгээс нэмж оруулах саналыг тусгах, багийн ИНХ-аар хэлэлцүүлж санал авах
		Баг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн саналыг сумын газрын даамалд хүргүүлэх
7		Бэлчээр ашиглалтын хуваарь, амрааж өнжөөх бэлчээрийн хуваарийг тогтоох

Бэлчээр газар тариалын хариуцсан мэргэжилтэн	Ган зудын үед өөр аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх асуудлыг судалж, зураглал схемийг гаргах
	Бэлчээрийн хортон, мэрэгчидтэй тэмцэх газрын төлөвлөгөөнд тусгах
	Бэлчээр хадланг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, ургац нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоо судалгааг гаргах
	Ган зуд, байгалийн гамшгийн давтамжийг иргэдэд сурталчлах, дасан зохицох менежментэд сургах, отор нүүдлийг хэрхэн зохион байгуулах саналыг боловсруулах
	Бэлчээрийн нөөц, даацтай уялдуулан малын үүлдэр угсааг сайжруулах, мал эрүүлжүүлэх, 1 малаас авах ашиг шимийг тооцох чиглэлийн үйл ажиллагааг төлөвлөн төлөвлөгөөнд тусгуулах

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР